

## Өвөрхангай аймгийн нутгаас шинээр илэрсэн хоёр бичээс, тамга

Эрдэмбилэгийн Саранболор<sup>1</sup>, Гончигийн Батболд<sup>2</sup>

**Товч агуулга:** Тус өгүүлэлд 2023 онд Өвөрхангай аймгийн Хархорин сумын Цагаан голын Бага хүрхрээ, Бат-Өлзий сумын Хүрмэн мухар хэмээх газруудаас шинээр илрүүлсэн руни бичгийн бага дурсгалын төрөлд багтах хоёр бичээс, холбогдох тамганы судалгааг толилуулж байна. Бидний судалгааны хэрэглэгдэхүүн болох тус бичээс хадны зураг, олон тамга тэмдэг бүхий газраас илэрсэн ажээ. Өвөрхангай аймгийн нутаг дахь Хүрмэн мухар, Цагаан голын Бага хүрхрээний хадны зургийг бүртгэн баримтжуулах явцад энэхүү хоёр бичээс, тамга зэргийг илрүүлжээ. Гэвч судлаачид тамга хэмээн үзэж дугаарлан тамганы бүртгэлд хамруулсан байна. Эртний Түрэг, Уйгур улсын төрийн бичиг байсан руни бичгийн цагаан толгойн нэг үсэг дангаараа утга илэрхийлсэн үг байхаас гадна бас заримдаа овог аймгийн тамгын үүргээр ч тохиолддог. Бид дээрх бичээсийг гэрэл зурагт тулгуурлан судалж өөрийн санал, таамаглалыг дэвшүүллээ. Бичээс, цуг сийлсэн тамга нэг он цагт хамаарах нь баттай бус боловч тамганы тархцаас ажиглахад уг тамга ихэвчлэн руни бичгийн дурсгалтай хамт тохиолдож байна. Энэ нь бидний дурдаж буй бичээс, тамга нэг цаг үед хамаарах боломжтойг харуулах нэгэн баримт юм. Бичээсийг уншиж холбогдох тамганы тархцыг тодорхойлохыг чухалчилсан бөгөөд тус сэдэвт холбогдох дараа дараагийн судалгаанд тус нэмэр болох боловч уу хэмээн үзэж байна.

**Түлхүүр үг:** Өвөрхангай аймаг, Бага хүрхрээ, Хүрмэн мухар, руни бичиг, тамга

### Удиртгал

Монгол улс болон хөрш зэргэлдээх улсуудаас хад чулуу, тахилын хавтан, мөнгөн болон модон эдлэл, шавар ваар, хөгжмийн зэмсэг, зоосон дээр бичигдсэн нийт 400 гаруй руни бичгийн бага дурсгал илрээд байгаа билээ. Тэдгээр дурсгалуудын талаас илүү хувь нь Монгол улсын нутаг дэвсгэрээс илэрсэн байх бөгөөд дийлэнхийг руни бичгийн бага дурсгал эзэлдэг байна. Руни бичгийн бага дурсгал хэдийгээр үсэг тэмдэг, мөрийн тоо цөөн, агуулга товч боловч ихэвчлэн бичээст шууд болон дам холбогдох тамгатай байдгаараа ихээхэн онцлогтой ажээ.

Жишээ нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг дахь Бөмбөгөрийн бичээст “Эртний Түрэгийн заншил ёсоор тэнгэрт хальсан гүнжийг чандарлаж тахил тайлга үйлдэж, хувцас тэргүүт эд өлөг оршоосон тахилын онгон үйлдсэн үйл явдлыг энэхүү гэрэлт хөшөөнд тэмдэглэж” (Баттулга 2022: 96) түүнд оролцсон гурван Карлук, гурван Басмыл зэрэг садан салбар овог аймгуудыг төлөөлсөн нэг тамганы хувилбар тамга, бусад овог аймгийн тамга нийлсэн нийт 35 ширхэг тамга сийлсэн байна. Олон тамгат Бөмбөгөрийн хөшөөг “Карлук, Басмыл нарт баттай

холбогдох руни бичгийн дурсгал мөн бөгөөд он цагийн хувьд 744-747 оны үед холбогдоно” (Баттулга 2022: 100) гэж үздэг байна.

Монгол улсын нутаг дэвсгэрээс илэрсэн руни бичгийн бага дурсгалуудад л тамга дагалдуулсан байдаг гэж өрөөсгөл ойлгож болохгүй. Түрэгийн хожуу хаант улсын цэргийн жанжин Илтириш Кутлуг хааны бага хүү Күл тигин жанжин, түүний ах Билгэ хаан нарт зориулсан гэрэлт хөшөө Ашина овгийн янгир тамгатай. Уйгур улсын хоёрдугаар хаан Тэнгэрт болсон улсыг хураасан Билгэ хаан (täñridä bolmīš āl ätmīš bilgä qaγan) буюу Моюн чурын гэрэлт хөшөө, Тариат, Тэсийн гэрэлт хөшөөнд Яглакар овгийн тамга сийлсэн байдаг. Гэрэлт хөшөөний мэлхий чулуун суурь, тахилын хавтан зэрэгт тухайн язгууртны овгийн тамга сийлэгдсэн байдаг бол харин зэл буюу балбал чулуунд оршуулгад оролцсон овог аймгууд тамгаа сийлсэн байх боломжтой юм.

Олон тамга бүхий гэрэлт хөшөөтэй тахилын онгоны цогцолбор дурсгалын сонгодог жишээ бол Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Донгойн ширээн дурсгал юм. Эрдэмтдийн судалгаанд “14 гэрэлт хөшөөний 48 хугархай, цэцгэн хээтэй хавтангийн том, жижиг 30 орчим хугархай гаргажээ. Гэрэлт хөшөөдийн 11-ийнх нь доод хэсэг уг суулгасан газартаа байжээ. Нийт 14 хөшөөнд түрэг бичээс, 11 хөшөөнд тамга, 2 хөшөөнд хятан бичээс...” хэмээн тэмдэглэсэнээс “одоогийн байдлаар Донгойн Ширээн

<sup>1</sup> ШУА, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Эртний түүхийн салбар

<sup>2</sup> ШУА, Археологийн хүрээлэн, Дундад зууны судалгааны салбар

\* Холбоо барих зохиогч: [ssaranbolor@gmail.com](mailto:ssaranbolor@gmail.com)

цогцолборын 3 хөшөөнд нийт 72 мөр, 3857 үсэг, 1193 үг, 86 илүү тамга байгааг тодотгоод байна” (Баттулга 2022: 22) хэмээн тэмдэглэсэн байна. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Батболд Донгойн ширээн тахилын онгоны гэрэлт хөшөөдийн тамганы эздийг тодорхойлсон сонирхолтой судалгаа хийсэн байна (2023: 47-72).

Дээрх баримтууд бичээст шууд болон дам холбогдох тамгыг заавал дагалдуулах ёс уламжлал байсныг харуулна. Гэвч бага бичээсийг дагалдуулсан тамгыг нэг цаг үед бичээстэй хамт сийлсэн үү, эсвэл бичээс бичихээс өмнө, хойно сийлсэн үү гэдгийг тогтоох боломжгүй юм.

Бичээс дагалдуулсан тамганы тухайд “Эртний овог аймгийн тархалт, оршин нутагласан газар нутаг, хил хязгаар хийгээд аян дайн, алба улаа, арилжаа худалдааны замыг тодруулан судлах сурвалж эх хэрэглэгдэхүүн болохын хувьд тамга судлал чухал ач холбогдолтойг өгүүлэх юун” (Баттулга 2022: 71-72) гэж тэмдэглэсэнтэй санал нэг байна. Эдгээрийг өгүүлэхийн учир нь бидний судлан буй бичээс нэг талаас нь авч үзвэл тамга мэт боловч нөгөө талаас нь судалж үзвэл яах аргагүй бичээс мөн юм. Тиймээс бид тус өгүүлэлд тамга хэмээн үзсэн тэмдэгтүүд тамга бус, харин руни бичгээр бичсэн үг болохыг тогтоон уншсан уншлага судалгааг толилууллаа.

### Бага хүрхрээний бичээс

Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Цагаан голын Бага хүрхрээний хойд эрэг дагуух хүрмэн хадны маш олон зураг байхаас гадна мөн цөөнгүй тамга тэмдэг байгааг баримтжуулж бүртгэсэн судалгаа нийтлэгдсэн байна (Цэцэгмаа 2023) (Зураг 1).

Гэрэл зургаас үзвэл, судлаачдын тэмдэглэсэн ʌ дүрс нь тамга биш харин үсэг тэмдэгт байх бүрэн боломжтой харагдаж байна. Учир нь уг дүрсийн хажуу талд ганц тамга сийлсэн байх нь бидний үзэж байгаагаар тэрхүү бичээсийн эзний овгийн тамга мөн бололтой. Руни бичгийн цагаан толгойд хатуу, зөөлөн буюу эр, эм гийгүүлэгчийг ялгаж тэмдэглэдэг. Үүнд, хатуу буюу эр үгийн “r” үсгийг ʌ тэмдэгтээр, харин эм үгийн “r” үсгийг ʌ тэмдэгтээр тэмдэглэдэг. Руни бичгийн цагаан толгойн ʌ “r” үсгийг äг гэж амилуулан уншиж болно. Монголын руни бичгийн сонгодог болон бага бичгийн дурсгалуудад дангаараа ʌ äг -эр, цэрэг гэх үг утгаар маш олон тохиолддог түгээмэл хэрэглээтэй үгсийн нэг юм.

Тамга сийлэгч өөрийн овог аймгийн тамгаа сийлсэн боловч тэр тамгыг хэн сийлсэн нь тодорхойгүй болсон тул ʌ äг гэж нэмж бичсэн бололтой. Үүний учир, ганц үсгээр илэрхийлсэн үг, тамга бүхий эл дурсгал “...тамгатай ... овгийн цэрэг бичив” гэсэн утга

агуулгатай хэмээн үзэж байна.

Ер нь руни бичгийн цагаан толгойн үсэг тэмдэгтийн зарим тохиолдолд тамгын үүргээр хэрэглэж байсанд эрдэмтэд руни бичгийн гарлыг тамгатай холбон тайлбарладаг бололтой.

Үсэг, тамганы чухам алиных нь үүргээр хаданд бичсэнийг танихад хэцүү бөгөөд жишээ нь, ʌ тэмдэгт нь руни цагаан толгойн “nt” үсэг мөн боловч нүдтэй “онги” тамга хэлбэрээр Говь-Алтай аймгийн Хөшөөт толгой (Аззаяа нар 2021), Хэнтий аймгийн Биндэрийн Рашаан хад, Идэрмэг сумын Төмстий уулын “Дүнгэнэдэг”-ийн хавтгай билүүн чулуу, Төв аймгийн Бүрэн сумын Бичигт Улаан хад, Ховд аймаг Дарви сумын Байшин үзүүрийн цагаан толгойн хад, Хануйн голын Шивээт улааны чулуун пайлуур, Дундговь аймгийн Баянжаргалан сумын Мөрт, Тайхир чулуу зэрэг газраас илэрснийг эрдэмтэн судлаачид (Пэрлээ 1976; Гантулга нар 2015: 266-267) тэмдэглэжээ.

Дээр дурдсан ганц үсгээр тэмдэглэсэн үгтэй адил нэг үсгээс бүтсэн үг руни бичгийн дурсгалд цөөнгүй тохиолдоно. Жишээ нь эм үгийн “b” гийгүүлэгчийг тэмдэглэсэн ʌ b үсэг тэмдэгтийг амилуулж “äb” гэж унших бөгөөд “гэр” гэсэн утгатай. Уг үгийг монгол хэлний eblekü- эвлэх, эвлүүлэх, нийлүүлэх гэдэг үгийн язгуураас гаралтай, үсгийн дүрс ч гэрийн ханын хэлбэрээс үүссэн гэх санал ч бий.

Тэгвэл руни бичгийн ʌ nt үсэг тэмдэгттэй төстэй тамга Төв аймгийн Бүрэн сумын Бичигт Улаан хад / Цагаан хороот/, Дундговь аймгийн Баянжаргалан сумын Мөрт, Бугатын тахилын онгоны зэл чулуу, Гэндэн булгийн тахилын онгоны зэл чулуу зэргээс илэрчээ.

Энэ мэт руни бичгийн цагаан толгойн үсгүүд дангаараа байвал тамга, харин хоёр болон түүнээс дээш тэмдэгт байгаа тохиолдолд бичээс байх магадлалтай байна. Цаашид энэ мэт тамга гэж тэмдэглэсэн дурсгалуудыг дахин шалгаж бидний энэ санал таамаглалыг баталж, эсвэл үгүйсгэх боломжтой юм.

Бид Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Цагаан голын Бага хүрхрээний хоёр тамга гэж тэмдэглэсэн дурсгалын нэг нь бичээс, харин нөгөө нь тамга гэж үзэв. Хаданд ʌ “r” үсэг тэмдэгтийн руни бичгийн дурсгалуудад уг үсгийг тэмдэглэх тигтэй ижил хурц үзүүртэйгээр бичсэн бол харин тамгыг мохоо, гогцоорч дугуйрсан хэлбэртэй дүрсэлсэн байна.

Бичээсийн эхийн сийрүүлэг: ʌ

Үсгийн галиг: r

Үгийн галиг: äг

Орчуулга: эр, цэрэг

Бага хүрхрээний ʌ äг гэх ганц үг бүхий бичээс анх удаа илэрч байгаа бус ОХУ-ын Уулын Алтайгаас мөн ʌ äг тэмдэгт бүхий дурсгал илэрчээ. Ганц үсэг бүхий

А-59 (Зураг 2) дугаартай бичээсийг И.Л.Кызласов 1994 онд илрүүлж, И.В.Кормушин уншиж “*эр, нөхөр, эрэгтэй хүн*” гэсэн утгатай гэж тайлбарлав (Kormuşin 2016: 255-256).

Үүнтэй төстэй А-31 (Kormuşin 2016: 251-252) бичээс нь хоёр тэмдэгтээс бүрдэх бөгөөд **ᠮ** гэж бичигдэж, **ᠠ** нь “эр” гэх утга, харин **ᠨ** нь заах утга илэрхийлж буй нөхцөл гээд “түүний хүнийг (түүний эрийг, түүний цэргийг)” хэмээн орчуулжээ. Мөн ялгаатай нэгэн орчуулга буй нь “**Arin!**” буюу “Хай!” хэмээн захиран тушааж буй үгээр орчуулсан бололтой хэмээн таамаглаж байна. Учир нь эм үгийн “**г**” үсгээр тэмдэглэсэн үгийг “**Ārin**” хэмээн уншсан бол “эрж, хайх” гэх утгыг илэрхийлэх боломжтой аж. Гэвч судлаач ямар нэг тайлбар өгөлгүй орчин цагийн турк хэлнээ “**Arin!**” хэмээн орчуулсан үг хэрэв “хайх” гэх утгатай үг бол “**Araın**” хэмээн бичвэл зөв болох байв.

Алтай, Енисейн бичээст “**er**” гэх үг “**är atım ...**”, “**uetmiş är ölürtim ...**” буюу “Дайчин нэр минь ...”, “Далан эрийг хөнөөв ...” гэх зэргээр тохиолдоно. Үүнээс үзэхэд, дайн байлдаанд манлайлан оролцох баатар эрсэд тэдний алдар цуу, эрэлхэг гавьяаг нь илтгэсэн өргөмж нэр олгодог байсан бололтой. Тиймээс бичээст дайнд байлдаанд орох миний эрэлхэг нэр минь гэсэн утгаар “**är atım-** миний цэрэг нэр минь, миний эрэлхэг нэр минь” гэсэн үгийг хэрэглэсэн байж болох юм. Харин “Далан эрийг хөнөөв” гэдэг нь далан хүнийг биш олон цэрэг дайчдыг хөнөөснийг тэмдэглэж буй бололтой.

Цэрэг дайны холбоотой үгсийн язгуур **är-** бөгөөд руни бичгийн дурсгалын **är-хүр-**, **нэх-**, **гүйц-**, **äri-** нэхэхтүн, **är ton-**хуяг дуулга гэх мэт үгсийг дурдаж болно.

Енисейн руни бичгийн дурсгалууд утга агуулгын хувьд өөр хоорондоо төстэй бөгөөд аян дайнд явахад ард нь үлдэж хоцорч байгаа эхнэр, үр хүүхэд, эд хөрөнгөндөө сэтгэл хоргодсон, ихэд харамссан харууслын үгс зонхилсон байдаг. Тэдгээр бичээст “**er adım**” гэх өгүүлэмж тохиолдохыг эрдэмтэд ихэвчлэн “**savaşçı erin adı**” буюу “дайчин эрийн нэр” хэмээн орчуулсан байна. Хакас-Минусын сав газраас илэрсэн мөнгөн аяган дээрх бичээсийг судлаачид “взрослое имя” буюу “насанд хүрсэн эрийн нэр” хэмээн тайлбарласан бөгөөд Енисейн бичээст түгээмэл тохиолддог болохыг дурджээ (Кызласов 1994: 202).

Руни бичгийн бага дурсгалд тохиолдох “**är**” хэмээх үгийн шууд “эр” гэж буулгаж болох боловч өгүүлбэрийн утга, хам сэдвээс хамаарч эр, эрэгтэй хүн, насанд хүрсэн хүн гэсэн утгаар, мөн цэрэг, дайчин, эр цэрэг, цэрэг дайчид гэсэн утгаар ч орчуулдаг. Монгол нутгаас **ᠠ** **är** гэх үг бүхий хамгийн сүүлийн үед судалгааны эргэлтэд орсон дурсгал бол Уйгурын Хар балгасаас илэрсэн хүрэл ялтас дээрх руни бичээс юм. МУИС-ийн профессор Ц.Баттулга,

У.Эрдэнэбат нар бичээсийн эхийг **ᠡᠷᠠᠨ.2 ᠠᠶᠢᠨ.1** гэж сийрүүлээд 1. **quᠷi** **är** 2. **qıᠲany** гэж галиглан уншжээ. Хүрэл ялтас дээрх бичээс “Бүс нь эр (цэрэг) Хятаных” буюу Хятан эр [цэрэг] -ийн бүс гэсэн утгатай ажээ. Эрдэмтэд ялтасны хэмжээ 2.9 см урт, 1.7 см өргөн, 0.1 см нимгэн дөрвөн буландаа нүхтэй, нүхний голч 0.15 см болохыг дурдаад бичээсийг хэр баргийн хүн энгийн нүдээр олж харахааргүй боловч микро дуран, галт шилээр томруулж үзвэл маш тодорхой сайн харагдана. Бичгийн боловсролтон, өндөр чадвартан уг бичээсийг бичсэн болох нь үсэг тэмдэгтийн зурлага, тиг хэлбэрээс илт. Хоёр мөр руни бичээсийг хүрэл тоногийг үйлдэх үед, магадгүй уг ялтсыг цугтасан урлаач, дархан бичсэн байх магадлалтай гэж дүгнэжээ. (Баттулга, Эрдэнэбат 2023: 108-110). Ер нь тухайн үед хамгийн өргөн хэрэглээтэй үгсийн тоонд **ᠠ** **är** цэрэг гэдэг үг байсан нь эргэлзээгүй юм.

## Тамга



Бичээсийн хажууд байх тамга нь тухайн бичээсийг бичсэн овгийн тамга байх боломжтой бөгөөд үүнтэй ижил тамгууд Увс аймаг Ачит нуур (Баттулга 2022), Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Бага Ойгур уул, Алтанцөгц сумын Хаш баг, Цэнгэл сумын Шивээт хайрхан, Бугат сумын Хатуугийн гол, Баян-Өлгий аймгийн музейд байх улаан боржин чулуунаа (Өмирбек 2015), Завхан аймаг, Завханмандал сум, Олон Индэрт (Анхсанаа 2018) зэрэг буй гэж тэмдэглэгджээ. Сүүлийн үеийн археологийн судалгааны баримтаас үзэхэд эл тамга Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөлөөс бусад бүх аймгийн нутагт тэмдэглэгдсэн байна гэжээ (Баттулга 2022: 166). Одоогийн байдлаар тус тамгыг аль нэг овгийн тамга мөн гэж баттай үзсэн судалгаа байхгүй ч нийтээр Түрэгийн үеийн тамга гэж тэмдэглэсээр иржээ.

Судлаач Г.Анхсанаа 2013 онд Завхан аймгийн Завханмандал сумын Олон индэрт хэмээх газарт соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэх явцдаа бидний өгүүлэн буй тамгатай ижил тамгыг илрүүлсэн бөгөөд тус тамганы хажууд могой тамгын олон хувилбар тамга буйг тэмдэглэжээ (Анхсанаа 2018) (Зураг 3).

Тэгвэл энэхүү хос унжлагат буйлан тамгатай ижил тамгууд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум Цагаан голын бага хүрхрээ **ᠠ**, Дундговь аймаг Баянжаргалан сумын Мөрт **ᠮ**, Говь-Алтай аймгийн Цагаан гол **ᠠ**, Хануй голын Шивээт улааны чулуун пайлуур **ᠠ** зэрэг газраас тус тус илэрсэн байна.

Судлаач Б.Өмирбек хос шулуун болон хос сараг унжлагат буйлан тамгыг бидний өгүүлж буй **ᠠ** тамганы төрөл хэмээн үзэж “...аргаль, янгир хүрлийн үеэс бидний өвөг дээдсийн шүтээн болж ирсэн эртний нүүдэлчид, монгол ба казахуудын оюуны соёлд тодорхой байр суурь эзэлсэн энэ амьтдыг тамга


тэмдгийн зүйлсэд лавтайяа эрт дээр үеэс хэрэглэсэн биз ээ” (Өмирбек 2015) гэж дүгнэжээ.

Гэвч бидний таамаглаж байгаагаар тус хос саран болон шулуун унжлагат буйлан тамга нь бидний өгүүлэн буй тамганы төрөл биш хэмээн үзэж байна. Учир нь дээрх дүрслэл бүхий тамгууд нь хурц үзүүртэй мөн харьцангуй богино байгаа ба  тамганы анхдагч эсвэл хувилбар тамга нь Бага Ойгурын бичээсийн хажууд байх  тамга мөн хэмээн үзэж байна. Тус тамгын холбогдох он цагийн хувьд “Бага Ойгурын бичээсийг үсэг тэмдэгтийн зурлага, зонхилох тамгад тулгуурлан Уйгурын үеийн бичгийн дурсгал гэж он цагийг баримжаалан тогтоож болох юм” хэмээн эрдэмтэн Ц.Баттулга тэмдэглэжээ.

### Хүрмэн мухар

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Хүрмэн мухар нь Орхон голын хойд эрэгт байрлалтай ба хүрмийн урд энгэрээр бүлэг зураг, тамга тэмдэг байдаг ажээ. 2023 онд хэвлүүлсэн судалгаанд “...янгир 49, буга 3, тамга 4, араатан 3, үл мэдэгдэх амьтад 34 байна” (Цэцэгмаа 2023: 21) хэмээн тэмдэглэжээ (Зураг 4). Судлаач дөрвөн тамга байна гэснийг нягталбал, эдгээрийн гурав нь тамга, харин дөрөв дэх тамга гэсэн нь хоёр үсэг бүхий руни бичгээр бичсэн үг болох нь баттай харагдаж байна. Бичээсийг гэрэл зургаас харахад цагийн уртад элэгдэж баларсан шинж тэмдэггүй, тод хэвээр үлджээ. Бичээсийн үсэг тэмдэгтийн өндөр 10-15 см, өргөн 13 см, тамганы өндөр 43 см, өргөн 13 см ажээ.

Бичээс болон тамга хэмжээний хувьд маш том бөгөөд бидний өгүүлэн буй тамгатай ижил тамга хажууханд нь байгаа тухай тус тамгыг олж илрүүлсэн каталогт хэвлэгдсэн ч хоёр дахь тамганы чухам хаана нь байгаа тухай мэдээлэл тэмдэглэгдээгүй байна.

Бичээсийн эхийн сийрүүлэг: 





Үсгийн галиг: s ü

Үгийн галиг: sū

Орчуулга: *цэрэг, цэргүүд*


Уг үгийг цэрэг гэж орчуулж буй боловч цаад утгаараа цэргүүд буюу олон цэрэг, хороо цэрэг гэсэн утга бас агуулж байдаг өвөрмөц үг юм. Монгол хэлэнд цэрэг цэрэглэх гэвэл дайн байлдаанд явж буй цэргийн анги нэгтгэл, хорооны олон цэргийг, цэрэг татлага гэвэл мөн л армид элсүүлэх цэргүүдийн бүртгэж сонгон шалгаруулахыг хэлдэг. Үүнээс цэрэг гэдэг үг ганц болон олны утга илэрхийлдэг онцлогтой болох нь ажиглагдана. Эртний түрэг хэлний sū нэр язгуурт үйл үг бүтээх –le дагавар залгаж sūle- цэрэглэ-, дайр-, довтол-, эзэл- гэх цэрэг дайны үйл хэргийг илтгэсэн үйл үг бүтээсэн байдаг. Түрэгийн хожуу хаант улс үеийн дурсгалаас Күличурын гэрэлт хөшөөнд, мөн Уйгурын үеийн руни бичгийн дурсгалуудад “čerig”


гэх үг тэмдэглэгдсэн нь монгол хэлний цэрэг (čerig) гэдэг үгтэй ижил юм.






Монголын руни бичгийн дурсгалуудаас Сүүжийн бичээс, Тайхир чулууны 31-р бичээс, Их нарт, Хутаг уулын 3-р бичээс, Зааны ангалын бичээст тус тус , ,  sū, sūs, sūsi гэх бичлэг бүхий  sū нэр язгуурт үгс тэмдэглэгдсэн байна.


Эрт, дундад үеийн түрэг хэлэнд цэргийн хороо, анги нэгтгэлийн захирагчийг sūbaşı гэдэг бөгөөд уг үгийг задлан үзвэл sū нь үндсэн утгаараа цэрэг, цэргүүд, шилжсэн утгаараа цэргийн хороо, анги нэгтгэл, арми гэсэн утгатай, харин baş нь толгой, тэргүүн утгатай юм. Тус хоёр үгийг нийлүүлж цэргийн анги, нэгтгэлийн захирагч буюу цэрэг, армийн командлагч гэсэн утгатай үг үүсгэсэн аж (Donuk 1988: 103).


### Тамга

Тус хоёр тамга нь  хоёул бичээсийн хажууд байгаа хэмээн дугаарласан байна. Ромбо хэлбэрийн толгойтой могой сүүлтэй тамга Төв аймгийн Бүрэн сумын Бичигт Улаан хад /Цагаан хороот/ цогцолбор дурсгалд хоёр тохиолдож байхаас гадна Эрмитажийн музейд хадгалагдаж буй руни бичигтэй аяганы сууринд сийлсэн тамга (Кызласов 1994: 303) мөн энэ төрөлд хамаарч байна. Харин дугуй толгойтой, могой сүүлтэй тамга мөн Төв аймгийн Бүрэн сумын Улаан хаданд хоёр, Өмнөговь аймгийн Далан уулын үзүүр, Бичигт гэх газраас тус тус хоёр илэрснийг тэмдэглэжээ.


Эрмитаж-д хадгалагдаж буй мөнгөн аяганы ёроол дахь E-83 (Зураг 5) бичээст бидний өгүүлж буй тамга  -тай ижил тамга буй бөгөөд тус аяганы ёроолд руни бичиг бүхий тэмдэгтүүд бий. Тус үсэг тэмдэгтийг тайлан унших судалгааг анх А.Н.Бернштам хийжээ.




     тэмдэгтүүдээр аяганы ёроол дахь үсгүүдийг мөнгөн аяган дээр он цагийн уртад нэмэгдэж үүссэн зураас зэргээс ялган тэмдэглэсэн байна. Тэрээр бичээсийг “Чунтыба (?) большого хозяина, добро имущество” (Бернштам 1946: 69) буюу “Их эзний чунтыба (?), эд хөрөнгө” хэмээн уншсан байна. Гэвч үсэг тэмдэгтийн галиг байхгүй тул хэрхэн уншсан нь тодорхойгүй байна.

Могой тамга нь  Тунра аймгийн тамга мөн болох тухай (Батболд 2017: 174) судалгаа бий. Могой тамганы толгой хэсэг дэх дүрсүүд өөрчлөгддөг нь могой тамгаас салбарласан тамгууд байх хэмээн таамаглаж байна. Иймд дурдагдаж буй бичээсийн тус хоёр тамга тэгш өнцөгт дүрс бүхий толгойтой, могой сүүлтэй эл тамга тунрагаас салаалсан овог аймгийн тамга байх боломжтой юм.

 тамга болон хувилбар тамгууд



<b>Тамга</b>							
<b>Байршил</b>	Ачит нуур, Увс	Бага Ойгур, Улаанхус, Баян-Өлгий	Шивээт хайрхан I, Цэнгэл, Баян-Өлгий	Шивээт хайрхан II, Цэнгэл, Баян-Өлгий	Хаш баг, Алтанцөгц, Баян-Өлгий	Хатуугийн гол, Бугат, Баян-Өлгий	Олон Индэрт, Завханмандал, Завхан

 тамга болон хувилбар тамгууд

<b>Тамга</b>				
<b>Байршил</b>	Хүрмэн мухар, Бат-Өлзий, Өвөрхангай	ОХУ-ын Эрмитаж	Бичигт Улаан хад (Цагаан хороот), Бүрэн, Төв	Бэрх уулын Лавиртын бууцны хад, Тайшир, Говь-Алтай



**Дүгнэлт**

Өвөрхангай аймгийн Хархорин сумын Цагаан голын Бага хүрхрээний бичээсийг гэрэл зургаас зэрвэс ажиглахад, бидний рун бичгээрх үг хэмээн үзсэн үсэг тэмдэгт нь түүний хажууд сийлсэн тамганы бүрэн бус дүрслэл бүхий хувилбар мэт харагдана. Гэвч сайн ажиглавал үсэг тэмдэгт болоод тамга хоёрыг сийлсэн ялгаа нь маш тодорхой харагдана. Бичээс дэх үсгийн тигийг бусад руни бичгийн дурсгалд тэмдэглэгдсэн үсгийн тигтэй харьцуулан үзэж, мөн энэ төрлийн тамганы дүрстэй тулган үзсэний эцэст “äg” буюу “эр, цэрэг, дайчин эр, эр цэрэг” гэх утгатай үг байгааг тогтоосон юм.

Тамга сийлэгч этгээд өөрийн овгийн тамгыг сийлсний дараа, тэр овог аймгийн цэрэг гэдгээ илэрхийлэхийн тулд  äg цэрэг гэж бичсэн байж болох юм. Эсвэл бичигч этгээд  äg цэрэг гэдэг үг бичээд аль овог аймгийн цэрэг болохоо тодруулахын тулд тамга сийлсэн байж ч болно. Юутай руни бичгийн дурсгал гэдэг нь лавтай байна.

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Хүрмэн мухарын бичээс нь “sü” буюу “цэрэг, арми” гэх утга бүхий үг гэдэг нь тун тодорхой юм. Бичээст дагалдуулсан хоёр ижил тамга харьцангуй өргөн тархацтай, тухайн үеийн нийгэмд нэр нөлөө овог аймгийн тамга болох нь илэрхий байна. Бид уг тамгыг Тунра аймгийн могой тамганы хувилбар байх магадлалтай хэмээн үзлээ.

Өвөрхангай аймгийн ойр залгаа орших хоёр дурсгалт газраас илрүүлэн бүртгэсэн хадны зураг,

тамга тэмдгийн зүйл дотор  äg,  sü гэсэн үг тохиолдож буй нь санамсаргүй зүйл биш. Учир нь энэ газар нутагт Түрэг, Уйгурын үед цэрэг, цэргийн анги нэгтгэл байрлаж байсныг харуулах түүхэн баримт хэмээн үзэж болно.

Энэхүү судалгаа нь тамга гэж андуурагдсан ганц хоёр үг бүхий руни бичгийн дурсгал цөөнгүй байх боломжтойг харуулж байна. Харин тамга судлахад үндсэн тамгыг эхлээд олж тогтоогоод улмаар хувилбар тамга байх боломжтойг тамгыг нэгтгэн судалбал илүү үр дүнд хүрэх боломж их байхаас гадна тамгыг эзэмшиж байсан овог аймгийг зөв олж тогтооход ч чухал ач холбогдолтой болно.

**Abstract**

**Two newly discovered inscriptions and stamps from Övörkhangaï province**

**Erdembileg Saranbolor and Gonchig Batbold**

In this article, we present the first reading of two newly discovered small runic inscriptions and the study of related stamps found in Kharkhorin soum, Tsagaan Goliin Baga Khürkhree and Bat-Ölzii soum, Khürmen Mukhar located in Övörkhangaï province. The main source material for our study was found in a place with numerous other rock paintings and stamps. These two inscriptions and stamps were discovered during the process of recording and documenting the rock paintings in Khürmen Mukhar and Baga Khürkhree in Övörkhangaï Province. However, the

researchers referred to the runic inscriptions as stamps and included them in the stamp register.

The runes were the state script of the ancient Turkic and Uyghur states. Sometimes a single letter of the runic alphabet can have its own meaning. In addition to being an expressive word, it also sometimes serves as a tribal seal. We present our suggestions and predictions based on the photos we received.

It is not certain that the inscriptions and engraved stamps belong to the same year, but judging from the distribution of the stamps, they usually occur with runic inscriptions. The fact that they belong to the same era as the inscriptions and stamps we are referring to shows the possibility. It is important to determine the scope of the related seal by reading the inscription. It is believed that this will be helpful for future research related to the topic.

**Keywords:** Övörkhangaï province, Baga Khürkhree, Khürmen Mukhar, runic inscriptions, stamps

### Ном зүй

Анхсанаа, Г. (2018). Олон Индэргийн тамга тэмдгийн дүрслэлүүд. *Köktürk yazısının okunuşun* 125. *Yılında Orhun'dan Anadolu'ya Uluslararası Türkoloji Sempozyumu, Bildiriler kitabı*. 1. Cilt. 145-149.

Анхсанаа, Г., Энхбат, Г. (2017). Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XI дэвтэр, Завхан аймаг. УБ.

Батболд, Г. (2023). Түрэг, Уйгурын үеийн аймгуудын тамганы сэргээлтийн урьдчилсан үр дүн. Нүүдэлчдийн өв судлал, Tomus XXIV, Fasc 1-22, 47-72. УБ.

Батболд, Г. (2017). Мартагдсан Пүгү аймаг. Дундад эртний Төв Азийн нүүдэлчдийн түүх, археологийн судалгааны асуудалд. УБ.

Баттулга, Ц. (2022a). Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа (Vol. Монголын баруун бүс нутаг дахь руни бичгийн дурсгал). УБ.



Зураг 1. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Цагаан голын Бага хүрхрээний бичээс болон тамга (Цэцэгмаа 2023)

Баттулга, Ц., Эрдэнэбат, У. (2023). Хар балгасаас илэрсэн хүрэл ялтас дээрх руни бичээс. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol. 12 (1), No.11. pp. 108-110. УБ. <https://doi.org/10.22353/mjaac.2023120111>.

Бернштам, А. (1946). Социально-экономический строй Орхоно-Енисейских тюрок VI-VIII веков. Восточно-Тюркский каганат и Кыргызы. Изд-во Академии Наук СССР. Москва.

Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Магай, Ж. (2014). Хойд Тамирын хөндий дэх эртний тамга тэмдгүүд. *Археологийн судлал*, Tomus XXXV, 249-273. УБ.

Кызласов, И.Л. (1994). Рунические письменности евразийских степей. Восточная литература РАН. Москва.

Өмирбек, Б. (2015) Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дэх тамга тэмдгийн дүрслэлүүд. *Археологийн судлал*, Tomus XXXV. Fasc 18. 274-286. УБ.

Пэрлээ, Х. (1976). Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. ШУА. УБ.


Цэцэгмаа, Б. (2023). Орхоны хөндийн хадны зургийн судалгаа. УБ.

Azzaya, B., Gerelmaa, N., Bayartuul, B. (2021). Runic Inscriptions and Tamgas in Govi-Altai Province, Mongolia. *Asian studies in Mongolia*, Vol.1 No.1:11-27. <https://doi.org/10.22353/asinmongolia.v1i1.967>

Donuk, A. (1988). *Eski Türk Devletlerinde İdarî ve Askerî Unvan ve Terimler*. Türk Dünyası Araştırmaları Vakfı. İstanbul.

Kormuşin, İ. V. (2016). *Yenisey - Altay - Kırgızistan Yazıtları ve Kâğıda Yazılı Runik Belgeler*. Bilgesu Yayıncılık. Ankara.

Received: March 18, 2024; Revised: Apr 15, 2024; Accepted: Apr 30, 2024




Зураг 2. Енисей дэх E-59 бичээс (Kormuşin 2016: 256)



Зураг 3. Завхан аймгийн Завханмандал сумын Олон индэртийн тамга (Анхсанаа, Энхбат 2017: 52)



Зураг 4. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Хүрмэн мухарын бичээс болон тамга (Цэцэгмаа 2023)



Зураг 5. ОХУ-ын Эрмитажд хадгалагдаж байгаа мөнгөн аяган дээрх бичээс, тамга (Кызласов 1994: 303)